УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
СУРГАЛТЫН
ХҮРЭЭЛЭН

БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС (ТАЙВАНЬ)-ЫН ҮНДСЭН ХУУЛЬ, АУДИТЫН БОЛОН ХЯНАЛТЫН ХУУЛИУД

Лавлагаа мэдээлэл

2023.03.13

Хянасан: Ц.Цогзолмаа (ПССХ-ийн захирал)

Судлаачид: Г.Билгээ (Зөвлөх)
Ц.Ариунаа (Эрдэм шинжилгээний ажилтан)
П.Уранчимэг (Референт)

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

АГУУЛГА

Бүгд Найрамдах Сингапур Улсын Үндсэн хууль.....2

Бүгд Найрамдах Сингапур Улсын Аудитын тухай хууль.....4

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (Тайвань)-ын Үндсэн хууль.....11

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (Тайвань)-ын Хяналтын тухай хууль.....13

-

Бүгд Найрамдах Сингапур Улсын Үндсэн хууль[1]

Ерөнхий аудиторыг томилох

148F.(1) Ерөнхий аудиторыг Ерөнхий Сайдын зөвлөсний дагуу Ерөнхийлөгч томилох буюу улираан томилно. Хэрэв Ерөнхийлөгч нь Ерөнхий Сайдын зөвлөмжтэй санал нийлэхгүй бол өөрийн үзэмжээр шийдвэрлэнэ.

(2) Ерөнхий Сайд энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу зөвлөхөөсөө өмнө Төрийн албаны комисс (Public Service Commission)-ын даргатай зөвлөлдөнө.

(3) Ерөнхий аудитор нь дараах байгууллагын үйл ажиллагаанд аудит хийж, тайлагнах үүрэгтэй:

(а) Засгийн газрын бүх яам, байгууллага;

(б) Парламент;

(в) Дээд шүүх, харьяа бүх шүүхүүд;

(г) Төрийн албаны комисс, Шүүхийн үйлчилгээний комисс (Judicial Service Commission), Хууль зүйн үйлчилгээний комисс (Legal Service Commission).

(4) Ерөнхий аудитор нь Засгийн газар, төрийн бусад байгууллага, төрийн сангууд (public funds)-ыг захиран зарцуулдаг байгууллагуудын дансанд аудит хийх, хуулиар олгогдсон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

(5) Ерөнхий аудитор энэ зүйлийн (7), (8) дахь хэсэгт заасны дагуу зургаан жилийн хугацаатай томилогдох ба тус бүр зургаан жилийн хугацаатай дахин томилогдох эрхийг нь хязгаарлахгүй.

(6) 2001 онд хүчингүй болгосон.

(7) Ерөнхий аудитор өөрийн хүсэлтээр Ерөнхийлөгчид бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд албан тушаалаасаа чөлөөлөгдөж болно.

(8) Хэрэв Ерөнхийлөгч нь Ерөнхий Сайдын зөвлөмжтэй санал нийлсэн бол Ерөнхий аудиторыг албан тушаалаас нь чөлөөлж болно. Ерөнхий Сайд нь Ерөнхий аудиторыг албан үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон (биеийн буюу оюун санааны эрүүл мэндийн асуудал үүссэн, эсхүл бусад өөр шалтгаанаар), зүй бус авирласнаас бусад тохиолдолд, мөн энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор байгуулагдсан Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон Ерөнхий шүүгчийн томилсон бусад хоёр шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүхийн зөвшөөрлөөс бусад тохиолдолд ийм зөвлөмж өгөхгүй.

(9) Энэ зүйлийн (8) дахь хэсэгт заасан шүүх уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор өөрийн хуралдааны дэг, дүрмийг гаргаж болно.

[1] Constitution of the Republic of Singapore. [9 August 1965] 2020 Revised edition. This revised edition incorporates all amendments up to and including 1 December 2021 and comes into operation on 31 December 2021. https://sso.agc.gov.sg/Act/CONS1963#top

(10) Ерөнхий аудиторын цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг Парламентын тогтоолоор тогтоох ба урамшууллыг Нэгдсэн сан (Consolidated Fund)-гаас олгоно.

(10A) Ерөнхий аудиторын ажиллах нөхцөлийн талаар хуулиар зохицуулаагүй бол Ерөнхийлөгч нь холбогдох журмыг энэхүү Үндсэн хуульд нийцүүлэн гаргаж, сонин (Gazette)-д нийтэлж болно.

(10B) Энэ зүйлийн (10A)-д заасан журамд Ерөнхий аудиторт олгох аливаа урамшуулал, нэмэгдлийг Нэгдсэн сангаас олгохоор зааж болно.

(11) Ерөнхий аудиторын цалин хөлс, ажлын бусад нөхцөлийг түүнийг дахин томилогдон ажиллах хугацаанд нь дордуулж өөрчлөхгүй.

---o0o---

Бүгд Найрамдах Сингапур Улсын 1966 оны Аудитын тухай хууль[2]

Энэ хуулиар Сингапур Улс болон төрийн бусад байгууллагууд, төрийн сангууд (public funds)-ыг захиран зарцуулдаг байгууллагуудын данс, түүнтэй холбоотой асуудлаар аудит хийх тухай харилцааг зохицуулна.

БҮЛЭГ 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Товч нэр

1.Энэ хуулийг 1966 оны Аудитын тухай хууль гэж нэрлэнэ.

Нэр томьёоны тайлбар

2.(1) Энэ хуульд өөр агуулга илэрхийлээгүй бол:

“төрийн байгууллага” гэж Ерөнхийлөгч, Засгийн газар, аливаа бичмэл хуулиар бүрэн эрхээ хэрэгжүүлдэг хууль ёсны байгууллага, Дээд шүүх, харьяа шүүхүүдээс бусад шүүхийн байгууллага, дээр дурдсан албан тушаалтан буюу байгууллагаас томилогдсон, эсхүл нэрийнх нь өмнөөс үүрэг гүйцэтгэгч албан тушаалтан буюу байгууллагыг хэлнэ;

“төрийн сан” гэж хувь хүн, аж ахуйн нэгж, эсхүл байгууллагаас аливаа зээл, итгэмжлэл, эсхүл сайн дурын төлбөрийн хэлбэрээр Сингапур Улсын иргэд, эсхүл тэдний нэг хэсгийн ашиг тусын тулд зарцуулахаар төлөвлөсөн, эсхүл зарцуулсан мөнгө, бонд, өр төлбөр, үнэт цаасыг хэлнэ;

(2) Энэ хуульд ашигласан үг, нэр томьёо нь өөр агуулга илэрхийлэх шаардлагагүй, эсхүл энэ хуульд өөрөөр илэрхийлээгүй бол 1966 оны Санхүүгийн журмын тухай хууль (Financial Procedure Act 1966)-д тодорхойлсон агуулгаар ойлгоно.

БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ЭРХ, ҮҮРЭГ

Ерөнхий аудиторын үүрэг

3.(1) Ерөнхий аудитор нь Засгийн газрын бүх яам, газар (Төрийн албаны комиссын ажлын албыг оролцуулан), Дээд шүүх, харьяа шүүхүүд, Парламентын дансанд аудит хийж, тайлагнана.

(2) Ерөнхий аудитор болон түүний удирдлагад хамаарах албан хаагчид энэ зүйлийн (1) дэх хэсэгт дурдсан байгууллагуудын данстай холбоотой бүх тооцооны хуудас, бүртгэл, баримт, тайлантай ямар ч үед танилцах эрхтэй.

(3) Ерөнхий аудитор нь энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасны дагуу хийсэн аудитын тайланг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх ба Ерөнхийлөгч уг тайланг Парламентад танилцуулна.

[2] Audit Act 1966. 2020 Revised edition. This revised edition incorporates all amendments up to and including 1 December 2021 and comes into operation on 31 December 2021 - https://sso.agc.gov.sg/Act/AA1966

(4) Ерөнхий аудитор нь аливаа бичмэл хуулийн дагуу Засгийн газар, төрийн байгууллагууд, төрийн сангуудыг захиран зарцуулах эрх бүхий байгууллагуудын данстай холбоотой бусад үүргийг гүйцэтгэх, бусад эрхийг хэрэгжүүлнэ.

Төрийн байгууллагууд, төрийн сангуудыг захиран зарцуулдаг байгууллагуудын дансанд аудит хийх

4. (1) Ерөнхий аудитор нь:

(а) аливаа бичмэл хуульд заасны дагуу төрийн аливаа байгууллагын дансанд аудит хийнэ;

(б) хэрэв аливаа бичмэл хуульд заагаагүй бол Сайд (the Minister)-ын зөвшөөрлийн дагуу, төрийн байгууллага, төрийн сангуудыг захиран зарцуулах эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан тохиолдолд, тухайн байгууллагын дансанд аудит хийнэ.

(2) Энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасан аудитын төлбөрийг тухайн байгууллагын хөрөнгөөр барагдуулна.

(3) Хэрэв аливаа бичмэл хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн (2) дахь хэсэгт заасан аудитын төлбөрийн хэмжээг Сайд тогтооно.

(4) Хэрэв Сайд нь нийтийн ашиг сонирхол шаардаж байна гэж үзвэл төрийн аливаа байгууллагын данс, түүнд аудит хийхтэй холбоотой аливаа бичмэл хуулийн заалтыг үл харгалзан байгууллагын дансанд Ерөнхий аудитор аудит хийх үүрэг өгнө.

(5) Энэ зүйлийн (4) дэх хэсэгт заасан аудит нь төлбөргүй байна.

Гүйлгээний аудитад мөрдөх журам

4А. (1) Ерөнхий аудитор энэ хуулийн 4 дүгээр зүйлийн (2), (3) дахь хэсэгт заасны дагуу дараах тохиолдолд хувь хүнтэй холбоотой шалгалт хийж, тайлагнаж болно:

(а) төрийн аливаа байгууллага, Дээд шүүх, харьяа шүүхүүд, эсхүл Парламентаас:

(i) буцалтгүй тусламж, татаас, урьдчилгаа мөнгө буюу зээл, ажил гүйцэтгэх, эсхүл хохирол барагдуулах баталгаа;

(ii) аливаа хөрөнгө, эсхүл хувь хүнтэй ашиг сонирхол бүхий санхүүгийн дэмжлэг;

(б) төрийн аливаа байгууллага, Дээд шүүх, харьяа шүүхүүд, эсхүл Парламенттай байгуулсан гэрээний дагуу, эсхүл тэдгээрт хамаарал бүхий туслан гүйцэтгэгчийн хувьд аливаа бараа, үйлчилгээг (эсхүл хоёулаа) нийлүүлэх;

(в) төрийн аливаа байгууллага, Дээд шүүх, харьяа шүүхүүд, эсхүл Парламентын өмнөөс мөнгө хураах буюу зарцуулах.

(2) Энэ хэсэгт хамаарах аудит хийх нөхцөл нь дор дурдсаны аль нэгийг нотлох баримтад нийцсэн байхаар хязгаарлагдана:

(а) хувь хүн, эсхүл хуулийн этгээд энэ зүйлийн (1)(а)-д заасан тэтгэлэг, татаас, урьдчилгаа мөнгө буюу зээл, ажил гүйцэтгэх, эсхүл хохирол барагдуулах баталгаа санхүүгийн дэмжлэг хүлээн авсан;

(б) хувь хүн, эсхүл хуулийн этгээд энэ зүйлийн (1)(б)-д заасан бараа, үйлчилгээ (эсхүл хоёулаа) нийлүүлсэн;

(с) хувь хүн, эсхүл хуулийн этгээд энэ зүйлийн (1)(б)-д заасан мөнгө цуглуулсан буюу тараасан.

(3) Сайд энэ хэсэгт заасан аудит нь нийтийн ашиг сонирхолд нийцэж байна хэмээн үзэж Ерөнхий аудиторт үүрэг өгснөөр уг аудитыг хийнэ.

(4) Энэ зүйлийн (1)(б)-д заасан “гэрээ” гэсэн нэр томьёог төрийн байгууллага, Дээд шүүх, харьяа шүүхүүд, эсхүл Парламентын захиалгаар аливаа бараа, үйлчилгээг (эсхүл хоёулаа) нийлүүлэх үүргийг биелүүлэх, эсхүл ийнхүү биелүүлэхэд нэмэр болж буй нөхцөлийг тусгасан гэрээг ойлгоно.

Аудит хийх

5. (1) Ерөнхий аудитор аудит хийх явцдаа үндэслэл бүхий бүх арга хэмжээг авсан эсэхийг шалгах шаардлагатай гэж үзсэн аливаа шалгалтыг хийнэ:

(а) Ерөнхий аудиторын шалгах зүйлд улсын мөнгөн хөрөнгө, эсхүл бусад мөнгөн хөрөнгийг хураасан, хадгалсан байдал;

(б) Ерөнхий аудиторын шалгах зүйлд холбоотой мөнгийг гаргах, төлбөр төлөх ажлыг зохих эрх мэдэлтний шийдвэрээр хийсэн, харин төлбөрийг зохих ёсоор хийсэн, шаардлага хангахуйц эрхийн бичгээр, эсхүл төлбөрийн баримтаар баталгаажсан байдал;

(в) Ерөнхий аудиторын шалгах зүйлд холбоотой мөнгийг хурааж, битүүмжилсэн байдал нь Үндсэн хууль, Санхүүгийн журмын тухай хууль болон бусад бичмэл хуульд бүх талаар нийцэж байгаа эсэхийг баталгаажуулсан байдал.

(2) Ерөнхий аудитор нь энэ зүйлийн (1) дэх хэсэгт харшлахгүйгээр, энэ хуулийн 4А дугаар зүйлд заасны дагуу хувь хүнтэй холбоотой аудит хийх явцдаа үндэслэл бүхий бүх арга хэмжээг авсан эсэхийг шалгах шаардлагатай гэж үзсэн аливаа шалгалтыг хийнэ:

(а) хувь хүн, эсхүл хуулийн этгээд энэ хуулийн (4А) дугаар зүйлийн (1)(а)-д заасан тэтгэлэг, татаас, урьдчилгаа мөнгө, эсхүл зээл, ажил гүйцэтгэх, эсхүл хохирол барагдуулах баталгаа болон санхүүгийн дэмжлэгийг хүлээн авсан байдал;

(б) хувь хүн, эсхүл хуулийн этгээд энэ хуулийн (4А) дугаар зүйлийн (1)(б)-д заасан бараа, үйлчилгээг (эсхүл хоёулаа) нийлүүлсэн байдал;

(в) тухайн хүн, эсхүл хуулийн этгээд энэ зүйлийн (1)(в)-д заасан мөнгийг хураасан буюу зарцуулсан байдал.

Ерөнхий аудиторын бүрэн эрх

6. (1) Ерөнхий аудитор Үндсэн хууль болон энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах бүрэн эрхийг эдэлнэ:

(а) бүрэн эрхийнхээ хүрээнд аливаа этгээдээс тайлбар, мэдээлэл авах;

(б) дор дурдсан байранд нэвтрэх, дотор нь ажиллах, аливаа баримт, бүртгэл, тэмдэглэл, баримт хайх, хуулбарлан авах:

(i) төрийн аливаа байгууллага, Дээд шүүх, харьяа шүүхүүд, Парламентын байр;

(ii) энэ хуулийн 4А дугаар зүйлд заасан аудит хийх шаардлага бүхий аливаа хувь хүний буюу хуулийн этгээдийн байр;

(iii) энэ зүйлийн (3)(б)-д заасан хувь хүн нь энэ хэсгийн (i), эсхүл (ii)-д заасан хувь хүн, эсхүл аж ахуй нэгжид хамаарах аливаа бүртгэл, мэдээлэл, баримт бичгийг эзэмшиж байгаа буюу хадгалж байгаа этгээдийн аливаа байр;

(в) аудитын шалгах зүйлтэй холбоотой бүх бүртгэл, эрхийн бичиг, баримт, бэлэн мөнгө, марк, үнэт цаас, эсхүл бусад хөрөнгийг гаргуулж авах;

(г) дараах тохиолдолд энэ хэсгийн (б)-д заасан аливаа байраас техник хэрэгсэл, тэмдэглэл, мэдээлэл, баримт болон бусад зүйлийг хураах авах:

(i) энэ зүйлийн (2)(а)-д заасан тэмдэглэл, мэдээлэл, баримтыг гаргаж өгөх тухай мэдэгдэл өгсөн ч заасан хугацаанд нь гаргаж өгөөгүй бол;

(ii) Ерөнхий аудитор аливаа бичмэл хуулийг зөрчсөн үйлдлийн нотлох баримтыг олж авахад шаардлагатай гэж үзсэн бол;

(д) Ерөнхий аудитор чиг үүргийг зохих ёсоор гүйцэтгэхэд шаардагдах бүх асуудлыг шалгахад чадамжтай гэж үзсэн аливаа этгээдээр тангараг өргүүлж, мэдүүлэг авч шалгах;

(е) аливаа төрийн албан хаагч, эсхүл бусад этгээдийг өөрийнхөө нэрийн өмнөөс лавлагаа, шалгалт, аудит хийлгэж, өөрт нь тайлагнах үүрэгтэйгээр томилж ажиллуулах;

(ё) Ерөнхий прокуророос хууль зүйн аливаа асуудлаар зөвлөгөө авах.

(2) Энэ зүйлийн (1)(а)-д заасан аливаа этгээдээс тайлбар, мэдээллийг авахдаа дараах байдлаар хэрэгжүүлнэ:

(а) тухайн этгээдэд хадгалагдаж байгаа, эсхүл түүний хяналтад байгаа тусгайлсан төрлийн бүртгэл, мэдээлэл, баримтыг тохиромжтой хугацаанд гаргаж өгөхийг бичгээр шаардах;

(б) энэ хэсгийн (а) хэсэгт заасан бүртгэл, мэдээлэл, баримтын талаар тайлбар өгөхийг тухайн этгээдээс шаардах;

(в) хэрэв бүртгэл, мэдээлэл, баримт тухайн хүнд байхгүй тохиолдолд тэдгээрийг хаана байгаа талаар өөрийн мэдэх зүйлээ хэлэхийг түүнээс шаардах;

(г) хэрэв мэдээллийг ойлгомжгүй өгсөн тохиолдолд уг мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр Ерөнхий аудиторт гаргаж өгөхийг шаардах.

(3) Энэ зүйлийн (2) дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор бүртгэл, мэдээлэл, баримтыг “хяналтдаа” байлгаж байгаа этгээд гэдгийг дараах байдлаар ойлгоно:

(а) тухайн этгээд бүртгэл, мэдээлэл, баримтыг эзэмшиж байгаа бол;

(б) тухайн этгээд бусдын эзэмшилд байгаа бүртгэл, мэдээлэл, баримтыг хадгалж байгаа бол.

(4) Ерөнхий аудитор нь энэ зүйлийн (1)(б)-д дурдсан байранд дор дурдсаныг хийх эрхтэй:

(а) аливаа зүйлд үзлэг, шинжилгээ хийх, гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх;

(б) Ерөнхий аудитор албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай гэж үзсэн бол аливаа хүн, техник хэрэгсэл, материалыг авч орох;

(в) Ерөнхий аудиторт энэ зүйлд заасны дагуу албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай дэмжлэг үзүүлэхийг тухайн байранд байгаа аливаа хүнээс шаардах.

(5) Ерөнхий аудитор нь ямар нэгэн төлбөргүйгээр дор дурдсаныг хийх эрхтэй:

(а) энэ зүйлийн (1)(б)-д дурдсан байранд нэвтрэх, байрлах;

(б) энэ зүйлийн (1), эсхүл (2)-т заасны дагуу Ерөнхий аудиторт өгсөн, эсхүл (1)(г)-д заасны дагуу олж авсан аливаа бүртгэл, мэдээлэл, баримт бичгийг хайж олох, аливаа бүртгэл, мэдээлэл, баримт бичиг болон тэдгээрийн хуулбар, тэдгээрээс гаргаж авсан зүйлийг хадгалах.

(6) Энэ зүйлд заасан Ерөнхий аудиторт олгосон бүрэн эрхийг Ерөнхий аудитор өөрөө, эсхүл эрх бүхий аливаа хүнээс бичгээр эрх олгогдсон төрийн албан хаагч хэрэгжүүлж болно.

(7) Ерөнхий аудитор буюу энэ зүйлийн (6) дахь хэсэгт заасан эрх олгогдсон төрийн албан хаагчийн шаардсанаар аливаа этгээд аливаа тайлбар, мэдээлэл, бүртгэл, баримт гаргаж өгөх, эсхүл аливаа асуултад хариулах бол уг мэдээллийг тайлбарлах, бүртгэлийг баримтжуулах, асуултад шаардлагын дагуу тодорхой хариулах үүрэгтэй.

Өөрийн эсрэг мэдүүлэх өгөх

6А. (1) Хувь хүн дор дурдсан эрхийг эдлэхгүй байж болно –

(а) өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл ногдуулах шийтгэлээс өөрийгөө хамгаалах тухайд ердийн хуулиар олгосон давуу эрх;

(б) хэрэв аливаа хуулиар мэргэжлийн онцлогтой эрх буюу бусад эрх нь хамгаалагдсан, эсхүл олон нийтийн ашиг сонирхолд хамаарсан бол Ерөнхий аудитор буюу эрх олгогдсон төрийн албан хаагчийн шаардлагын дагуу аливаа тайлбар, мэдээлэл өгөх, бүртгэл, баримт гаргаж өгөх, эсхүл асуултад хариулахаас татгалзах эрх.

(2) Гэсэн хэдий ч:

(а) тайлбар, мэдээллийн зорилгоор шууд болон шууд бусаар олж авсан аливаа мэдээлэл, баримт, эд зүйл;

(б) тэмдэглэл, баримт гаргаж өгөх, эсхүл асуултад хариулах нь тухайн хүний эсрэг баримт болох бол 1871 оны Эрүүгийн хууль (Penal Code 1871)-ийн 177 дугаар зүйлд зааснаас, эсхүл тайлбар, мэдээлэл, асуултын хариултыг худал мэдүүлснээс бусад тохиолдолд иргэний, эсхүл эрүүгийн аливаа хэрэг хянан шийдвэрлэхэд хувь хүний эсрэг нотлох баримт болохгүй.

(3) Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу холбогдох мэдээлэл, бүртгэл, баримтыг илрүүлэх, үйлдэх, эсхүл хэрэглэх нь аливаа хуулиар хамгаалагдсан мэргэжлийн онцлогтой эрх буюу бусад эрх, эсхүл олон нийтийн ашиг сонирхолд нөлөөлөхгүй

Нууцлал

7. (1) Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа нь түүнийг зохицуулсан тусгайлсан бичмэл хуульд өөрөөр заагаагүй бол бусад бичмэл хуулийн заалт (нууцтай холбоотой заалтыг оролцуулан)-аар хязгаарлагдахгүй.

(2) Бичмэл аливаа хуульд зааснаас үл хамааран, нууцлалыг хамгаалах тангараг өргөсөн буюу баталгаа өгсөн байдлыг үл харгалзан энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг гүйцэтгэсний төлөө тухайн этгээдийг буруутгаж, торгууль ногдуулж үл болно.

(3) Ерөнхий аудитор, эсхүл өөр аливаа этгээд нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу аливаа мэдээлэл, бүртгэл тооцоо, баримт бичгийг шууд болон шууд бусаар олж авсан бол энэ хуулийн дагуу үүрэг гүйцэтгэж байгаа өөр хүнд шилжүүлэн өгөхөөс бусад тохиолдолд өөр бусад этгээдэд задруулах буюу мэдээлэхийг хориглоно.

(4) Энэ зүйлийн (3) дахь хэсэг нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу олж авсан мэдээлэлд үндэслэсэн дүгнэлт, ажиглалт, зөвлөмжийг Ерөнхий аудиторын аливаа тайланд тусгах, олон нийтэд танилцуулах, бусдад мэдээлэхэд харшлахгүй.

Аудитын тайлан

8. (1) Сайд 1966 оны Санхүүгийн журмын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан мэдэгдэл бэлэн болсон даруйд нь Ерөнхий аудиторт хүргүүлэх ба тэрээр уг мэдэгдэлд аудит хийж, тайлан гаргах үүрэгтэй.

(2) Хэрэв санхүүгийн жил дууссанаас хойш долоон сарын дотор уг мэдэгдлийг хүлээн аваагүй бол Ерөнхий аудитор энэ тухай тайлангаа Ерөнхийлөгчид хүргүүлэх ба тэрээр уг тайланг хүлээн авснаас хойш нэг даруй Парламентад танилцуулна.

(3) Энэ зүйлийн (4) дэх хэсэгт заасны дагуу энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасан өргөдөлтэй холбоотой бүх тайланг Ерөнхий аудитор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх ба тэрээр тайлан, өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Парламентад танилцуулна. Хэрэв Парламентын чуулган хуралдаагүй үед хүлээн авсан бол дараагийн чуулган эхэлснээс хойш 14 хоногийн дотор танилцуулна.

(4) Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан аливаа мэдээллийг Ерөнхий сайд болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Сайдын зүгээс Батлан хамгаалах яамны Байнгын нарийн бичгийн дарга, Батлан хамгаалах хүчний нэгдсэн штабын дарга нарын зөвлөмжийн дагуу Сингапур Улсын батлан хамгаалах, аюулгүй байдалд зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаагаа илэрхийлсэн тохиолдолд Парламентад танилцуулахгүй.

(5) Ерөнхий Сайд болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Сайдын гарын үсэг бүхий аливаа баталгаа нь түүнд дурдсан асуудлын бүрэн нотолгоо болно.

(6) Хэрэв улсын мөнгө, улсын нөөцийн өмчийн бүртгэл, хадгалалтад аливаа ноцтой зөрчил гарсан гэж Ерөнхий аудитор үзсэн бол тэрээр энэ тухай нэн даруй Сангийн яамны Байнгын нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

(7) Ерөнхий аудитор нь энэ хуулийн дагуу гаргасан тайлангийн хүрээнд болон бусад хэлбэрээр зөвлөмж гаргахдаа улсын данс, улсын мөнгө, улсын нөөцтэй сантай холбоотой асуудлаар саналаа өгч болно.

(8) Хууль, эсхүл Сайдын тушаалд өөрөөр заагаагүй бол Ерөнхий аудитор нь аливаа байгууллагын дансанд аудит хийсэн бол Ерөнхий аудиторын гэрчилгээ, дансны талаар шаардлагатай гэж үзсэн аливаа тайланг танилцуулна.

(9) Энэ зүйлийг үл харгалзан Ерөнхий аудитор нь энэ хууль, бусад аливаа бичмэл хуулийн дагуу аливаа албан үүргээ гүйцэтгэх, эсхүл аливаа бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааныхаа талаар Ерөнхийлөгчид хэдийд ч тайлагнаж болно.

Нэмэлт зохицуулалт

9. (1) Сайд энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор зохицуулалт хийж болно.

(2) Энэ хуулийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан бүх зохицуулалтыг сонинд нийтлэгдсэний дараа нэг даруй Парламентад танилцуулна.

---o0o---

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (Тайвань)-ын Үндсэн хууль[3]

IX БҮЛЭГ. ХЯНАЛТ

90 дүгээр зүйл. Хяналтын Юан (Control Yuan – хяналтын эрх мэдэл) нь төрийн хяналтын эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага ба зөрчил арилгах арга хэмжээ авах, итгэл үзүүлэх эсэх, зэмлэх, аудит хийх эрх мэдлийг хэрэгжүүлнэ.

91 дүгээр зүйл. Хяналтын Юаныг аймгийн болон хотын зөвлөл, Монголын болон Төвдийн орон нутгийн зөвлөл, мөн гадаад улсад оршин суугаа Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын иргэдээс сонгосон гишүүдээс бүрдэнэ. Гишүүдийн тоог дараах байдлаар тогтооно:

1.аймаг тус бүрээс таван гишүүн;

2.Гүйцэтгэх Юан (Executive Yuan – гүйцэтгэх эрх мэдэл)-д шууд харьяалагддаг хот тус бүрээс хоёр гишүүн;

3.Монголын орон нутгийн зөвлөл болон хошуунаас найман гишүүн;

4.Төвдийн орон нутгийн зөвлөлөөс найман гишүүн;

5.гадаад улсад оршин суугаа БНХАУ-ын иргэдээс найман гишүүн.

92 дугаар зүйл. Хяналтын Юан нь гишүүдээсээ сонгосон Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчтэй байна.

93 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүн зургаан жилийн хугацаатай сонгогдох ба дахин сонгогдож болно.

94 дүгээр зүйл. Хяналтын Юан нь энэхүү Үндсэн хуульд заасны дагуу зөрчил арилгах арга хэмжээ авах эрхээ хэрэгжүүлэхдээ хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор шийдвэрлэнэ.

95 дугаар зүйл. Хяналтын Юан нь хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Гүйцэтгэх Юан, түүний яамд болон хороодоос гаргасан тушаалын эх хувь болон холбогдох бусад бүх баримт бичгийг авахаар шаардаж болно.

96 дугаар зүйл. Хяналтын Юан нь Гүйцэтгэх Юан, түүний яамд болон хороодын үйл ажиллагааны хүрээг харгалзан, тэдний хууль зөрчсөн, эсхүл албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан гэм буруутай эсэхийг тогтоох зорилгоор тэдний үйл ажиллагааг мөрдөн шалгахын тулд тодорхой тооны хороо байгуулж болно.

97 дугаар зүйл. Хяналтын Юан нь өөрийн хороодын мөрдөн шалгалт, шийдвэрийн үндсэн дээр зөрчил арилгах арга хэмжээний саналыг Гүйцэтгэх Юан, холбогдох яамд болон хороодод хүргүүлэх ба сайжруулахад чиглэсэн арга хэмжээнд хяналт тавьж болно.

Хяналтын Юан нь Төв Засгийн газар, эсхүл орон нутгийн засаг захиргааны төрийн албан хаагчийг хууль зөрчсөн, эсхүл албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан гэм буруутай гэж үзвэл зөрчил арилгах арга хэмжээ авах, эсхүл итгэл үзүүлэх эсэх талаар санал гаргаж болно. Хэрэв эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол уг хэргийг шүүхэд шилжүүлнэ.

[3] Constitution of the Republic of China (Taiwan). Announced Date: 1947-01-01. https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0000001

98 дугаар зүйл. Төв Засгийн газар, эсхүл орон нутгийн засаг захиргааны төрийн албан хаагчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг Хяналтын Юаны есөөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй хорооны нэг буюу түүнээс дээш гишүүн санал болгож, журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэсний үндсэн дээр Хяналтын Юан хэлэлцэнэ.

99 дүгээр зүйл. Хяналтын Юанаас Шүүхийн Юан (Judicial Yuan) болон Шалгалтын Юан (Examination Yuan)-ын албан хаагчдыг хууль зөрчсөн, эсхүл албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан гэх үндэслэлээр итгэл үзүүлээгүй бол энэхүү Үндсэн хуулийн 95, 97, 98 дугаар зүйлд заасан заалтыг мөрдөнө.

100 дугаар зүйл. Хяналтын Юанд Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг Хяналтын Юаны бүх гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь санал болгож, журмын дагуу хэлэлцсэний дараа олонхын саналаар шийдвэрлэнэ. Хяналтын Юаны нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлнэ.

101 дүгээр зүйл. Хяналтын Юаны гишүүн Юанд илэрхийлсэн санал, өгсөн саналын хариуцлагыг Юанаас гадуур хүлээхгүй.

102 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүнийг гэмт хэргийн газарт баривчлахаас бусад тохиолдолд Хяналтын Юаны зөвшөөрөлгүйгээр баривчлах, эсхүл албадан саатуулахыг хориглоно.

103 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүн төрийн албанд, эсхүл өөр мэргэжлээр хавсран ажиллаж болохгүй.

104 дүгээр зүйл. Хяналтын Юан нь Ерөнхий аудитортай байх ба түүнийг Хууль тогтоох Юан (Legislative Yuan)-ын зөвшөөрснөөр Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилно.

105 дугаар зүйл. Ерөнхий аудитор нь Гүйцэтгэх Юанаас орлого, зарлагын эцсийн тайланг ирүүлснээс хойш гурван сарын дотор хуульд заасан журмын дагуу аудит хийж, тайланг хууль тогтоох Юанд хүргүүлнэ.

106 дугаар зүйл. Хяналтын Юаны зохион байгуулалтыг хуулиар тогтооно.

---o0o---

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (Тайвань)-ын Хяналтын тухай хууль[4]

I БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хяналтын Юан (Control Yuan – хяналтын эрх мэдэл) нь Үндсэн хууль болон Үндсэн хуулийн нэмэлт заалт (Additional Articles of the Constitution)-д заасны дагуу итгэл үзүүлэх эсэх (impeachment), зэмлэх, аудит хийх бүрэн эрхийг хэрэгжүүлэх ба зөрчил арилгах арга хэмжээ санал болгоно. Аудитаас бусад бүрэн эрхийг энэ хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүн нь итгэл үзүүлэх эсэх, зэмлэх эрх мэдлийг хэрэгжүүлнэ, Хяналтын Юаны хороод нь зөрчил арилгах арга хэмжээг санал болгоно.

3 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүд бүхий л нутаг дэвсгэрт аливаа салбар чиглэлээр хяналт тавьж болно.

4 дүгээр зүйл. Хяналтын Юан болон түүний гишүүд иргэдээс гомдлыг бичгээр хүлээн авч болно; Хяналтын Юан энэ талаар журам тогтооно.

II БҮЛЭГ. ИТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЭСЭХ

5 дугаар зүйл. (Хүчингүй болсон)

6 дугаар зүйл. Хяналтын Юаны хоёроос доошгүй гишүүн санал болгосноор Хяналтын Юаны гишүүд хууль зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд төрийн албан тушаалтанд хариуцлага тооцно.

7 дугаар зүйл. Итгэл үзүүлэх эсэх асуудлыг бичгээр дэлгэрэнгүй санал болгоно; санал гаргасан гишүүд уг асуудлыг хянан шалгахаас өмнө нэмэлт мэдээлэл хийж болно.

8 дугаар зүйл. Санал гаргасан гишүүдийг оролцуулахгүйгээр ес буюу түүнээс дээш гишүүн хянан шалгаад хариуцлага тооцох ёстой гэж үзвэл Хяналтын Юан уг асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий сахилгын байгууллага (disciplinary organ)-д шилжүүлнэ. Хэрэв шинэ баримт, эсхүл нотлох баримт илэрсэн бол түүнийг хянан шалгасны дараа сахилгын байгууллагад шилжүүлнэ.

Итгэл үзүүлэх эсэх асуудлын талаарх шалгалтын хорооны шийдвэрийг гарын үсэг зурж санал хураах ба олонхын саналаар шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл. Итгэл үзүүлэх эсэх асуудлаар хянан шалгах ажлыг Хяналтын Юаны бүх гишүүд ээлжлэн явуулна.

10 дугаар зүйл. Хэрэв хянан шалгах явцад итгэл үзүүлэх эсэх хэрэг нь үндэслэлгүй гэж үзэж, санал гаргасан гишүүд энэ шийдвэрийг эсэргүүцсэн бол уг асуудлыг эцэслэн шийдвэрлэхийн тулд Хяналтын Юаны бусад ес буюу түүнээс дээш гишүүн дахин хянан шалгана.

[4] Control Act. Announced Date: 1947-01-01. https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0030199

11 дүгээр зүйл. Итгэл үзүүлэх эсэх хэрэгт холбогдолтой Хяналтын Юаны гишүүд уг хэргийг хянан шалгалтаас татгалзана.

12 дугаар зүйл. Хяналтын Юаны Ерөнхийлөгч нь аливаа тохиолдолд итгэл үзүүлэх эсэх асуудалд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохгүй.

13 дугаар зүйл. Хяналтын Юаны гишүүд болон түүний ажилтнууд хяналт шалгалтын дүгнэлт гарахаас өмнө итгэл үзүүлэх эсэх асуудлын талаар олон нийтэд мэдээлэхгүй.

Хяналтын Юан нь итгэл үзүүлэх эсэх хэргийн хяналт шалгалтын дүгнэлтийг олон нийтэд мэдээлнэ. Хэрэв уг хэрэг нь үндэсний аюулгүй байдал, дипломат харилцаа, эсхүл хуулиар нууцад хамруулсан бусад салбартай холбоотой бол уг нууц мэдээллийг хянан засварлана.

14 дүгээр зүйл. Хяналтын Юан итгэл үзүүлэх эсэх хэргийг сахилгын байгууллагад шилжүүлэх үед тухайн хэрэг нь хууль зөрчсөн, эсхүл албан үүргээ биелүүлээгүйн улмаас нэн даруй зөрчил арилгах арга хэмжээ авахаар хангалттай ноцтой гэж үзвэл, Хяналтын Юанаас гэм буруутай этгээдийн удирдах албан тушаалтан, эсхүл зөрчил арилгах арга хэмжээ авах эрх бүхий албан тушаалтанд тухайн зөрчлийг арилгах арга хэмжээ нэн даруй авахыг мэдэгдэнэ.

Удирдах албан тушаалтан нь ийнхүү мэдэгдэл авсан боловч гэм буруутай этгээдэд зохих хариуцлага тооцоогүй бол түүнийг албан үүргээ биелүүлээгүй гэм буруутайд тооцно.

15 дугаар зүйл. Хэрэв Хяналтын Юан итгэл үзүүлэх эсэхийг нь хөндсөн төрийн албан тушаалтныг эрүүгийн, эсхүл цэргийн хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзвэл, Хяналтын Юан уг хэргийг сахилгын байгууллагад шилжүүлэхээс гадна эрх бүхий шүүх, эсхүл цэргийн шүүхэд хуулийн дагуу арга хэмжээ авахуулахаар шилжүүлнэ.

16 дугаар зүйл. Итгэл үзүүлэх эсэх хэргийг сахилгын байгууллага болон ерөнхий харьяаллын шүүх, эсхүл цэргийн шүүхэд шилжүүлсэн бол эрх бүхий байгууллагууд яаралтай арга хэмжээ авч, авсан арга хэмжээний талаар Хяналтын Юанаар дамжуулан санал гаргасан гишүүдэд нэг даруй мэдэгдэнэ.

Итгэл үзүүлэх эсэхийг нь хөндсөн төрийн албан тушаалтныг өмгөөлсөн аливаа мэдэгдлийг Хяналтын Юанаар дамжуулан санал гаргасан гишүүдэд нэн даруй хүргүүлнэ. Санал гаргасан гишүүд мэдэгдэл хүлээн авснаас хойш арав хоногийн дотор санал, дүгнэлтээ сахилгын байгууллагад хүргүүлж болно.

17 дугаар зүйл. (Хүчингүй болсон)

18 дугаар зүйл. Итгэл үзүүлэх эсэхээс болж хариуцлага хүлээсэн этгээд албан үүргээс нь түдгэлзүүлсэн хугацаанд төрийн аливаа байгууллагад ажилд орохыг хориглоно.

Хариуцлага тооцох шийдвэр гарснаар тухайн этгээдийн хариуцлага хүлээх хугацаанд хууль ёсны дагуу албан тушаал дэвших эрх нь хүчингүй болно. Хэрэв сануулах арга хэмжээ авахуулсан бол дэвших эрх хүчинтэй хэвээр байна.

III БҮЛЭГ. ЗЭМЛЭХ

19 дүгээр зүйл. Хяналтын Юаны гишүүн нь төрийн албан тушаалтныг хууль зөрчсөн, эсхүл албан үүргээ биелүүлээгүйн улмаас албан үүргээс нь түдгэлзүүлэх, эсхүл нэн даруй зөрчил арилгах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн бол бичгээр зэмлэх ба үүнийг Хяналтын Юаны бусад гурав буюу түүнээс дээш гишүүн хянан шийдвэрлэнэ. Хяналтын Юан зэмлэлийг тухайн төрийн албан тушаалтны удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтанд илгээнэ. Хэрэв уг хэрэг нь эрүүгийн, эсхүл цэргийн хууль тогтоомж зөрчсөн гэж үзвэл уг хэргийг эрх бүхий шүүх, эсхүл цэргийн шүүхэд шилжүүлнэ.

Хяналтын Юаны гишүүн нь өөрийн хянах үүрэгтэй албан тушаалын зэргээс доогуур төрийн албан тушаалтанд зэмлэлийг бичгээр хүргүүлэх бол тухайн албан тушаалтны удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

20 дугаар зүйл. Хэрэв зэмлэсэн хэргийг үндэслэлгүй гэж үзэж, санал гаргасан гишүүд энэ шийдвэртэй санал нийлэхгүй бол Хяналтын Юаны бусад гурав буюу түүнээс дээш гишүүн дахин хянан шалгаж эцсийн шийдвэрийг гаргана.

21 дүгээр зүйл. Эрх бүхий шүүх, эсхүл цэргийн шүүхээр тусад нь хянан шийдвэрлэх эрүүгийн, эсхүл цэргийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой хэргээс бусад тохиолдолд төрийн албан тушаалтныг бичгээр зэмлэснийг эсэргүүцсэний дараа түүний удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь Төрийн албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах тухай хууль (Law of Discipline Against Public Functionaries)-ийн дагуу нэг сарын дотор уг хэргийг авч хэлэлцэнэ. Тэрээр зэмлүүлсэн төрийн албан тушаалтныг албан үүргээс нь түдгэлзүүлж болно. Хэрэв удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь тухайн этгээдэд хариуцлага тооцох шаардлагагүй гэж үзвэл үндэслэлээ Хяналтын Юанд мэдэгдэнэ.

22 дугаар зүйл. Удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь өмнөх зүйлд заасны дагуу зэмлэсэн хэргийг авч хэлэлцээгүй, эсхүл авсан арга хэмжээг нь Хяналтын Юаны хоёр буюу түүнээс дээш гишүүн зохисгүй гэж үзсэн бол зэмлүүлсэн төрийн албан тушаалтанд итгэл үзүүлэх эсэх асуудлыг хөндөнө.

Зэмлүүлсэн төрийн албан тушаалтны удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтан зэмлэсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш түүнд хариуцлага тооцоогүй, эсхүл хариуцлага тооцохгүй гэж шийдвэрлэсэн бол зэмлүүлсэн төрийн албан тушаалтанд илтгэл үзүүлэхгүй байх, удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтанд албан үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр тус тус хариуцлага тооцно.

23 дугаар зүйл. Зэмлүүлсэн хэрэгт энэ хуулийн 8, 11, 12, 13, 16 дугаар зүйлийг зайлшгүй өөрчлөлтүүдтэй хэрэглэнэ.

IV БҮЛЭГ. ЗӨРЧИЛ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

24 дүгээр зүйл. Хяналтын Юан нь Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагуудын ажил, чадавхыг мөрдөн шалгасны дараа холбогдох хороод зөрчил арилгах арга хэмжээнүүдийг хянан шалгаж, баталсны дараа Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагуудад тэдгээрийг санал болгож болно.

25 дугаар зүйл. Гүйцэтгэх Юан, эсхүл түүний харьяа яамд, хороод зөрчил арилгах арга хэмжээний талаар мэдэгдэл авсан даруйдаа сайжруулах буюу зохих арга хэмжээг авч,

сайжруулсан, авсан арга хэмжээнийхээ талаар Хяналтын Юанд бичгээр хариу өгнө. Хэрэв Хяналтын Юан хоёр сарын дотор хариу аваагүй бол холбогдох байгууллагад хандаж болно.

Гүйцэтгэх Юан нь нэн даруй сайжруулалт хийх, эсхүл зохих арга хэмжээ авах ба сайжруулалт, үйл ажиллагааны талаар хяналтын Юанд бичгээр хариу өгөх ёстой. Хяналтын Юан хоёр сарын дотор хариу өгөхгүй бол холбогдох байгууллагад хүсэлт гаргаж болно.

V БҮЛЭГ. МӨРДӨН ШАЛГАХ

26 дугаар зүйл. Хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд хяналтын гэрчилгээтэй Хяналтын Юаны гишүүн, эсхүл Хяналтын Юанаас томилсон шалгалтын гэрчилгээтэй ажилтан нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллага дээр очиж, хавтаст хэрэг, бүртгэл, холбогдох баримт бичгийг мөрдөн шалгаж болно. Эдгээр байгууллагын дарга, холбогдох бусад ажилтнууд мөрдөн шалгалтаас татгалзахгүй ба байцаалт авахад дэлгэрэнгүй хариулт өгч, байцаалтын тэмдэглэлд гарын үсгээ зурна.

Шалгагч хэргийг шалгахдаа энэ тухай гомдол бичгээр гаргаж үсэг зурсан этгээдэд мэдэгдэх ба шалгагдаж байгаа этгээдийг тогтоосон газарт дуудан байцаалт авч болно.

Шалгагч хэргийн агуулгыг нийтэд мэдээлэхгүй.

Хяналтын болон шалгалтын гэрчилгээг ашиглах журмыг Хяналтын Юан тогтооно.

27 дугаар зүйл. Шаардлагатай бол шалгагч нь холбогдох нотлох баримтыг түр хугацаагаар хураан авах, эсхүл бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хураан авч болно.

Ингэхдээ эхлээд тухайн байгууллагын даргаас зөвшөөрөл авна. Энэ нь үндэсний эрх ашгийг хохироохгүй бол байгууллагын дарга зөвшөөрөл олгоно.

Байгууллагын дарга нь шалгагчийн хураан авсан нотлох баримт дээр тамгаа дарж, баримт авна.

28 дугаар зүйл. Шалгагч нь орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн шүүх болон бусад холбогдох байгууллагаас туслалцаа авч болно.

Шалгагч эсэргүүцэлтэй тулгарсан, эсхүл нотлох баримтыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл шаардлагатай арга хэмжээ авахуулахаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.

29 дүгээр зүйл. Хэргийг чухал гэж үзсэн, эсхүл шалгуулагч оргон зайлж болзошгүй гэж үзвэл шалгагч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.

30 дугаар зүйл. Хяналтын Юан нь тодорхой асуудал, хэргийг мөрдөн шалгахын тулд өөр агентлагт даатгаж болно. Тус байгууллага хэргийг хүлээн авсны дараа нэн даруй мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлж, Хяналтын Юанд бичгээр хариу өгнө.

VI БҮЛЭГ. НЭМЭЛТ ЗААЛТУУД

31 дүгээр зүйл. Энэ хуулийг хэрэгжүүлэх журмыг Хяналтын Юан тогтооно.

32 дугаар зүйл. 32 дугаар зүйл. Энэ хуулийг нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэ хуулийн 1, 2, 5, 6 дугаар зүйл, 22 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг 1993 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---o0o---